

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 3 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцийг батлах тухай Засгийн газрын 2005 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 3 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчилсүгэй:

“1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

- Төрийн захиргааны төв удирдлагын хэлтэс;
- Орон нутгийн захиргаа, удирдлагын хэлтэс;
- Хуулийн хэлтэс;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс;
- Зохион байгуулалтын хэлтэс;
- Мэдээллийн технологийн алба;
- Төрийн ёслолын алба;
- Засгийн газрын хэвлэл мэдээллийн алба;
- Ерөнхий сайдын ажлын алба;
- Шадар сайдын ажлын алба.”

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХБОЛД

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 1 дүгээр
сарын 5-ны өдөр

Дугаар 3

Улаанбаатар
хот

Засгийн газрын Хэрэг эрхлэх
газрын бүтцийг батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

- төрийн захиргааны төв байгууллагуудын хэлтэс;
- орон нутгийн байгууллагуудын хэлтэс;
- хуулийн хэлтэс;
- мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс;
- зохион байгуулалтын хэлтэс;
- боловсон хүчин, санхүүгийн алба;
- төрийн ёслолын алба;
- Засгийн газрын хэвлэл мэдээллийн алба;
- Ерөнхий сайдын ажлын алба;
- Шадар сайдын ажлын алба.

2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагын орон тоог дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга тус бүр нэг байхаар тогтоосугай.

3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын орон тооны хязгаарыг 96-гаар тогтоосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус газрын бүтцийг батлах тухай” Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 205 дугаар тогтоолын 2 дугаар зүйл, “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2000 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 145 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ц.ЭЛБЭГДОРЖ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 145

Улаанбаатар
хот

Засгийн газрын Хэрэг эрхлэх
газрын бүтцийг шинэчлэн
батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 12, 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

а/төрийн захиргааны төв байгууллагуудын хэлтэс;
б/орон нутгийн байгууллагуудын хэлтэс;
в/мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс;
г/төрийн албаны боловсон хүчний хэлтэс;
д/хуулийн хэлтэс;
е/зохион байгуулалтын хэлтэс.

2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагын орон тоог дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга тус бүр нэг байхаар тогтоосугай.

3. Хэрэг эрхлэх газрын шинэ зохион байгуулалтын бүтцийн дагуу нэгжүүдийн чиг үүргийг шинэчлэн тогтоож, ажилтнуудыг зохистой байршуулах арга хэмжээг батлагдсан орон тоо, төсвөө хэтрүүлэхгүйгээр хэрэгжүүлэхийг тус газрын дарга Ө.Энхтүвшинд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байгуулах тухай" Засгийн газрын 1993 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 88 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагын орон тоог дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга тус бүр нэг байхаар тогтоож," гэсэн хэсэг, "Зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн тухай" Засгийн газрын 1998 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 168 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Засгийн газрын гишүүн,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 9 дүгээр
сарын 2-ны өдөр

Дугаар 168

Улаанбаатар
хот

*Зохион байгуулалтын бүтцийн
өөрчлөлтийн тухай*

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

- а/ танхимын үйл ажиллагааг дэмжих газар;**
- б/ стратегийн удирдлагын газар;**
- в/ төрийн захиргааны удирдлагын газар.**

2. *“Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байгуулах тухай”* Засгийн газрын 1993 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 88 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн “дэд дарга 1” гэснийг “тэргүүн дэд дарга, дэд дарга тус бүр нэг” гэж өөрчлөн найруулсугай.

3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн хүрээнд энэхүү тогтоолын 1 дүгээр заалтаар батласан бүтцийг нийцүүлэн ажиллахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга (Т.Лхагваа)-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан *“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”* Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 295 дугаар тогтоол, *“Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус газрын бүтцийг батлах тухай”* Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 205 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1996 оны 8 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 205

Улаанбаатар
хот

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл
ажиллагааны стратеги, зохион
байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн
хөтөлбөрийг зөвшөөрөх, тус газрын
бүтцийг батлах тухай*

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хавсралтын ёсоор зөвшөөрсүгэй.

2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

- а/ танхимын үйл ажиллагааг дэмжих газар;**
- б/ стратегийн удирдлагын газар;**
- в/ төрийн захиргааны удирдлагын газар;**
- г/ хүний нөөцийн удирдлагын газар;**
- д/ нийтлэг үйлчилгээний удирдлагын газар.**

3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын бүтцийн хүрээнд нэгжүүдийн чиг үүргийг шинэчлэн тогтоож, ажилтнуудыг зохистой байршуулах арга хэмжээг энэ оны 9 дүгээр сард багтаан хэрэгжүүлэхийг тус газрын дарга (Т.Лхагваа)-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын жишээн дээр боловсруулсан хөтөлбөрийг яам, тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлтэй холбогдсон асуудлыг боловсруулан мөрдүүлэхдээ арга зүйн үндэслэл болгон ашиглахыг Монгол Улсын сайд нарт даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байгуулах тухай” Засгийн газрын 1993 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 88 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн “тэргүүн дэд дарга”, “дэд дарга тус бүр нэг” гэснийг “дэд дарга 2” гэж өөрчлөн, мөн тогтоолын 3 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХСАЙХАН

Сангийн сайд

П.ЦАГААН

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1.0. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Оршил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид “Хөтөлбөр” гэх/-т Засгийн газрын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайлал, тэрчлэн нийтлэг үйлчилгээний удирдлагаар хангах асуудлыг хамарсан хамгийн тохиромжтой үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

Хөтөлбөр нь Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын нэг бөгөөд Танхимын стратегийн шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх эцсийн цэг болох Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас эхлэн төрийн захиргааны байгууллагын өөрчлөлт, шинэчлэлийг хийхэд арга зүйн чухал ач холбогдолтой юм.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Монгол Улсын Төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг, Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн “Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл” бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 төслийн “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратегийн талаархи зөвлөмж” /Засгийн газрын шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болон удирдлагын зохицуулах чиг үүргийг өөрчлөн шинэчлэх, төгөлдөржүүлэх тухай санал, 1995.3.1/-ийг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль
- Бусад хууль

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын шилдэг туршлага, байгууллагын үйл ажиллагааны стратеги (бизнес төлөвлөгөө)-ийг боловсруулах, дахин инженерчлэлийн аргаар бүтцийг тодорхойлох арга зүйг хэрэглэв.

Энэ арга зүйг үндэслэн Засгийн газрын үйл ажиллагааны стратегийн хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги (**эрхэм зорилго, стратегийн зорилт, гол зорилт**)-ыг тодорхойлов. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратегид тулгуурлан үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, тус газрын зохион байгуулалтын бүтцийн талаархи саналыг боловсруулав.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратегийг Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн бусад байгууллагын үйл ажиллагааны стратегитай уялдаа холбоотойгоор авч үзэж, тэдгээрийн дунд үүрэг, чиг үүргийн давхардал, хийдэгдэл гаргахгүй байхад анхаарав.


1.5. Удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллага нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг хариуцлага хүлээж, Ерөнхий сайд, Танхимд бүх талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлнэ.

Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллага нь Засгийн газрын стратегийн удирдлага, төлөвлөлт, Засгийн газрын үйл ажиллагааны зохицуулалт, бодлого, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд Засгийн газрын өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.


Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд оролцдог Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллага болох Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь *Засгийн газрын удирдлагын зөвлөхийн*, Сангийн яам нь *Засгийн газрын санхүү, эдийн засгийн зөвлөхийн*, Гадаад харилцааны яам нь *Засгийн газрын гадаад бодлогын зөвлөхийн*, Хууль зүйн яам нь *Засгийн газрын хуулийн зөвлөхийн* үүрэг хариуцлагыг тус тус хүлээнэ.

Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь



1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Засгийн газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр *үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч*-ийг зөв тодорхойлох нь Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагаас үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:



Засгийн газрын стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн олон төрлийн нарийн төвөгтэй хэрэгцээг хангахад чиглэнэ.

Засгийн газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний төрлийг үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч бүрээр тогтоох бөгөөд энэ нь Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын үйл ажиллагааны стратегийг зөв тодорхойлох нөхцлийг бүрдүүлнэ.

2.0. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын нэг болох Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд болон Ерөнхий сайд, Танхимын үйл ажиллагаанд бүх талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

1. Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд Засгийн газрын өөрийнх нь болон яам, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагааг төвлөрүүлэх, Засгийн газрын стратегийн удирдлага, төлөвлөлт, зохицуулалтыг шаардлагатай зөвлөлгөө, үйлчилгээгээр цаг тухайд нь хангах замаар Засгийн газарт үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад нь бүх талын дэмжлэг үзүүлэх;

2. Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага хооронд хэвийн бөгөөд үр, нөлөөтэй харилцаа тогтоох, төрийн захиргааны байгууллагын хэмжээнд удирдлагын хамгийн шилдэг арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;
3. Төрийн захиргааны байгууллагын өөрчлөлт, хөгжлийн стратегитай уялдсан хүний нөөцийн удирдлагын арга барилыг хэрэглэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг үе шаттайгаар хангах замаар төрийн захиргааны албыг итгэл хүндэтгэл хүлээсэн цомхон, чадварлаг алба болгон өөрчлөн хөгжүүлэх;
4. Засгийн газар, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд өртөг, зардлыг бууруулах болон үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн нийтлэг үйлчилгээг буй болгон хөгжүүлэх.

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын эрхэм зорилго нь улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахьсан хамгийн шилдэг бөгөөд цаг үеэ олсон зөвлөлгөө, бүх талын дэмжлэгээр Ерөнхий сайд Танхимыг хангах, Засгийн газрын үр нөлөөтэй, үр ашигтай, тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг баталгаатай хангах замаар эх орон, ард түмэндээ үнэнч шударгаар үйлчлэхэд оршино.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын эрхэм зорилго нь хамгийн шилдэг бөгөөд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон зөвлөлгөө, бүх талын дэмжлэгээр Ерөнхий сайд Танхимыг шуурхай хангах, Засгийн газрын үр нөлөөтэй, үр ашигтай, тасралтгүй, хэвийн жигд ажиллагааны таатай орчин бүрдүүлэхэд оршино.
/Ерөнхий сайд М.Энхсайханы санаачилгаар Засгийн газрын 1996 оны 310 дугаар тогтоолоор орсон өөрчлөлт/

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Стратегийн шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Үйл ажиллагааны стратегийн энэ зорилт нь Засгийн газрын үр нөлөөтэй, үр ашигтай, тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангахад чиглэнэ.

Энэ нь Ерөнхий сайд, Танхимд бодлогын шийдвэр гаргахтай холбогдсон үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын тэргүүн, Засгийн газрын хуралдааны даргынх нь хувьд Ерөнхий сайдыг шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөөгөөр хангах замаар хэрэгжинэ.

Стратегийн энэ зорилтын хүрээнд үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Ерөнхий сайд, Танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь хэвлэл, мэдээллийн байгууллага, ард иргэд, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам байна.

2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах

Үйл ажиллагааны стратегийн энэ зорилт нь Монголын ард түмэн өндөр мэргэшлийн, чадварлаг, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахисан төрийн захиргааны албаар үйлчлүүлэх баталгааг буй болгоход чиглэнэ.

Стратегийн энэ зорилтын хүрээнд үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь яам, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн удирдах ажилтан, төрийн албан хаагч байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь төрийн холбогдох бусад байгууллага, ард иргэд, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь боловсрол, сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллага, Монголыг дэмжигч орон, олон улсын байгууллага байх болно.

3. Нийтлэг үйлчилгээний удирдлагаар хангах

Стратегийн энэ зорилт нь Засгийн газрын хязгаарлагдмал нөөцийг үр нөлөөтэй, үр ашигтай ашиглах баталгааг буй болгоход чиглэнэ. Энэ нь Засгийн газрын төрөл бүрийн үйлчилгээг зохицуулсан нийтлэг үйлчилгээний механизмыг буй болгох замаар хэрэгжинэ.

Стратегийн энэ зорилтын хүрээнд үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага байх бөгөөд тэрчлэн улсын болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байж болох юм.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь өртөг, зардал багатай, чанар сайтай үйлчилгээ үзүүлэх чадвартай хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, Засгийн газрын бусад болон Засгийн газрын бус зарим байгууллага байна.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

1.0. Стратегийн шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд:

- 1.1. Танхимын стратегийн шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх;*
- 1.2. Засгийн газрын стратегийн удирдлага, төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;*
- 1.3. Санхүүгийн нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.*

2.0. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангахтай холбогдсон үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд:

- 2.1. Захиргааны удирдлагын манлайллыг хангах;*
- 2.2. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах.*

3.0. Нийтлэг үйлчилгээний удирдлагаар хангахтай холбогдсон үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд:


- 3.1. Засгийн газрын төрөл бүрийн үйлчилгээг зохицуулах механизмыг буй болгон хөгжүүлэх*
- 3.2. Дотоод дэмжлэг үзүүлэх үйлчилгээгээр хангах.*

2.6. Үйл ажиллагааны зорилт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги (бизнес төлөвлөгөө)-ийг дор дурдсанаар тодорхойлж байна:



3.0. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО, САНАЛ БОЛГОЖ БУЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ТЭДГЭЭРИЙН ҮҮРЭГ, ЧИГ ҮҮРЭГ

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим


Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

1. **Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тусгасан байх зарчим** (Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй уялдсан байх).
2. **Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим** (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх).
3. **Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим** (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, үүнд Засгийн газрын ажлын алба, түүний бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратегийг тусгасан байх).
4. **Бүтцийн хувьд энгийн байх зарчим** (Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн /гурваас дээшгүй/ шат дамжлагатай байх).
5. **Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим** (байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх).
6. **Улс төрөөс ангид байх зарчим** (Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Ерөнхий сайд, Танхимд улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахисан зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх).
7. **Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим** (Үйл ажиллагааны загвар нь чадавхиа хөгжүүлэхэд чиглэгдсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо

Дээр дурдсан зарчим болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратегийг үндэслэн тус газрын үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцоог санал болгож байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий тогтолцооноос дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгж урган гарч байна:

1. Танхимын үйл ажиллагааг дэмжих асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг

Энэ нэгж нь стратегийн шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх стратегийн зорилтын хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны нэг гол зорилт болох танхимын стратегийн шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх үндсэн үүргийг хүлээнэ. Энэ нь юуны өмнө Засгийн газарт хэлэлцүүлэхээр оруулж байгаа асуудлыг бэлтгэх болон Засгийн газрын хуралдаанаас гаргасан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах замаар хэрэгжинэ.

Стратегийн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх асуудал нь яам, тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, төрийн холбогдох байгууллага, хэвлэл, мэдээллийн байгууллага, олон нийт, ард иргэдтэй харилцах асуудалтай нягт холбоотой учраас үүнтэй холбогдсон чиг үүргийг хариуцна. Тэрчлэн яам, тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, холбогдох бусад байгууллагад Засгийн газарт оруулах асуудлыг боловсруулах, түүнийг Засгийн газрын бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулах талаар зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх зарим үүрэг хүлээнэ.

Зохион байгуулалтын бүтцийн энэ нэгжид стратегийн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх бүх чиг үүрэг төвлөрөх болно.

2. Стратегийн удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг

Энэ нэгж нь стратегийн шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх стратегийн зорилтын хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хувьд шинэлэг бөгөөд ач холбогдол нь өсөн нэмэгдэж байгаа үйл ажиллагааны гол зорилт нь болох Засгийн газрын стратегийн удирдлага, төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд өөрийн түнш болох Сангийн яам, Гадаад харилцааны яам, Хууль зүйн яамтай хамтран дэмжлэг үзүүлэх үндсэн үүргийг хүлээнэ. Тэрчлэн өөрийн түнш болох Сангийн яамны оролцоотойгоор санхүүгийн нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны гол зорилттой холбогдсон үүргийг хэрэгжүүлнэ.

3. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг

Энэ нэгж нь төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах стратегийн зорилтын хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны гол зорилт болох захиргааны удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээнэ.

Энэ нь төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага хоорондын харилцааг зохицуулах явдлыг зохион байгуулалтын бүтцийн энэ нэгжид хариуцуулах замаар хэрэгжинэ.

4. Хүний нөөцийн удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг

Энэ нэгж нь төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах стратегийн зорилтын хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны гол зорилтын нэг болох хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээнэ.

Төрийн захиргааны албаны зөвлөлийн ажлын албаны үүргийг Засгийн газрын ажлын алба гүйцэтгэх болсонтой холбогдон Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас энэ үүргээ хэрэгжүүлэхэд хүний нөөцийн удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж нь гол дэмжлэг үзүүлнэ.

Энэ нь байгууллагын өөрчлөлт, хөгжлийн стратегитэй уялдсан хүний нөөцийн удирдлагын зөвлөлгөө, зохицуулалт, үйлчилгээгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, төрийн холбогдох бусад байгууллагыг хангах замаар төрийн зорилт, чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх төрийн захиргааны албыг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ.

5. Нийтлэг үйлчилгээний удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг

Энэ нэгж нь нийтлэг үйлчилгээний удирдлагаар хангах стратегийн зорилтын хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратегийн нэг гол зорилт болох Засгийн газрын төрөл бүрийн үйлчилгээг зохицуулах механизмыг буй болгон хөгжүүлэх үндсэн үүргийг хүлээнэ.

Энэ нь Засгийн газар, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагыг нийтлэг үйлчилгээгээр хангах стратеги боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх идэвхтэй үйл ажиллагаа явуулж, өртөг зардлыг бууруулах, үйлчилгээний чанарыг сайжруулах, өргөжилтийн хэмнэлт гаргах замаар хэрэгжинэ.

Нийтлэг үйлчилгээгээр хангах, ажлыг дотоод зах зээлийн эдийн засаг, бизнесийн байгууллагын туршлагаар зохион байгуулж, зохицуулан удирдаж байх болно. Өөрөөр хэлбэл, зах зээлийн үнэ, ханшаар хэрэглэгч буюу үйлчлүүлэгчийн таашаалд нийцсэн үйлчилгээ үзүүлэх буюу өртөг, зардал багатай, чанар сайтай үйлчилгээний төлөө өрсөлдөөн буй болгох замаар нийтлэг үйлчилгээг хөгжүүлнэ. Гэхдээ нийтлэг үйлчилгээ буй болгох ажлыг бага зүйлээс эхэлж аажмаар өргөжүүлэх замаар үе шаттайгаар хийх болно.

Энэ нэгж нь нийтлэг үйлчилгээний удирдлагаар хангах стратегийн зорилтын хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны гол зорилтын нэг болох дотоод дэмжлэг үзүүлэх үйлчилгээгээр хангах үүргийг давхар хүлээнэ.

Энэ нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын захиргааны дотоод болон дотоод үйл ажиллагааг дэмжих үйлчилгээ, албан ажлын өрөөгөөр хангах, мэдээллийн тогтолцоо, архив, номын сангийн үйлчилгээ үзүүлэх, ажиллах нөхцөлийг нь хангах, зарим нийтлэг нөөцийг удирдаж зохицуулах замаар хэрэгжинэ.

---ooOoo---